



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хууль, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/153 дугаар захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Оюутны шигшээ багийн Чөлөөт бөхийн тамирчин ОУХМ Э.Бэхбаяр, З.Занабазар, Ц.Намуунцэцэг, дасгалжуулагч М.Баярсайхан нар нь "Рио-2016" Зуны олимпийн наадмын эрх авахаар Казакстан улсын Астана хот, Монгол улсын Улаанбаатар хотноо тус тус зохиогдох тэмцээнд Монгол улсаа төлөөлж оролцох тул 2015 оны 12 дугаар сарын 07-29-ны өдрүүдийг дуустал 23 хоногийн бэлтгэл сургуулилтанд хамрагдахаар явахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Оюутны шигшээ багийн чөлөөт бөхийн тамирчин, дасгалжуулагч нарын байр, хоолны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Э.Бэхбаяр, З.Занабазар, Ц.Намуунцэцэг, М.Баярсайхан нарын байр, хоолны зардалд шаардагдах 5.060.000 /Таван сая жаран мянга/ төгрөгийг оюутны шигшээ багийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны ...*12 дугаар*... сарын ...*02*...-ны өдрийн
О.Б.Б. дугаар тушаалын хавсралт

“Рио-2016 Олимпийн наадмын эрх олгох
тэмцээнд оролцох тамирчдын бэлтгэл сургуулилтанд
хамрагдахад байр, хоолны зардлын төсөв

№	Зардлын нэр	Зардлын хэмжээ /төг/	Нийт зардал /төг/
1.	Байр, хоолны зардал	23 хоног х 4 хүн х 55.000₮=5.060.000₮	5.060.000₮
Дүн			5.060.000₮

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг